

## АРИЛЖААНЫ БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ АСУУДАЛД

Д.Моломжамц\*, Б.Хишигдэлгэр\*\*

**Хураангуй:** “Covid-19” цар тахлын дэгдэлтийн улмаас манай улсын эдийн засгийн өсөлт удааширч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон билээ. Үүнтэй холбоотойгоор Засгийн газар, Төв банкны зүгээс аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор шат дараатай олон арга хэмжээ авч байна. Ялангуяа сүүлийн саруудад аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор арилжааны банкны зээлийн хүүг бууруулах асуудлыг нийгмийн өргөн хүрээнд ихээхэн хөндөх болсон. Энэхүү өгүүлэлд арилжааны банкны зээлийн хүүнд нөлөөлж буй гол хүчин зүйлүүд болон зээлийн хүүг бууруулахад анхаарах зарим асуудлыг авч үзсэн болно.

**Түлхүүр үгс:** арилжааны банк, зээлийн хүү, хадгаламж, валютын ханш, инфляци

## DETERMINANTS OF THE INTEREST RATE OF COMMERCIAL BANKS IN MONGOLIA

**Abstract:** Due to the COVID-19 pandemic, Mongolia has been facing an economic downturn and suspension of activities in the public and private sectors. The Mongolian Government and the Central Bank of Mongolia have been taking various measures to support these public and private sectors, entities, and individuals. One of which is lowering the loan interest of commercial banks in order to support the activities of entities, which has been a major disclosed consideration in recent months. This article will define the key factors that affect the loan interest of commercial banks and discuss the measures that should be taken prior to lowering the loan interest.

**Key words:** commercial bank, interest rate, savings, exchange rate, inflation

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E mail): molomjants0112@yahoo.co.jp

\*\* МУИС-ийн ШУС, Хүмүүнлэгийн ухааны сургууль (Email): mongoliabkd@gmail.com

## Удиртгал

Дэлхий дахинд Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын дэгдэлттэй байгаа өнөө үед улс орнуудын эдийн засгийн өсөлт саарч, олон мянган компаниудын үйл ажиллагаа доголдож, ажилгүйдлийн хэмжээ ихээхэн нэмэгдэж байна. Манай улсын хувьд ч 2020 он гарсаар экспорт, импортын хэмжээ буурч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа ихээхэн хумигдсаныг нийгэм, эдийн засгийн статистикийн тоо мэдээллүүд харуулж байна. Ийнхүү коронавирусын нөлөөгөөр улс орны эдийн засагт учирч буй “эдийн засгийн бус шок”-ийг зөөллөх үүднээс УИХ, Засгийн газар, Монгол банкны зүгээс шат дараалсан хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч цар тахлын дэгдэлтийн үргэлжлэх хугацаа тодорхойгүй, дэлхийн эдийн засгийн төлөв байдал сайнгүй, манай улсын эдийн засгийн нөөц боломж бага зэрэг олон хүчин зүйлүүд нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна. Ийм нөхцөлд цаашид авахаар төлөвлөж буй арга хэмжээнүүдийн нэг нь арилжааны банкны зээлийн хүүг бууруулах тухай асуудал болж байна.

Манай улсын хувьд арилжааны банкны зээлийн хүү бусад улс орнуудтай харьцуулвал харьцангуй өндөр тул зээлийн хүүг бууруулах замаар аж ахуйн нэгжүүдийн инновацийн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай. Гэхдээ арилжааны банкны зээлийн хүү нь тухайн улс орны нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлүүдийн үр дүнд бүрэлдэн тогтдог бөгөөд банкны салбар нь итгэлцлийн үндсэн дээр оршин тогтнодог маш эмзэг салбар тул энэхүү асуудалд туйлын болгоомжтой хандаж шат дараатай, эдийн засгийн оновчтой бодлогыг авч хэрэгжүүлэх замаар шийдвэрлэх ёстой.

### 1. Банкны салбарын эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг

Банкны салбар бол өнө эртний түүхтэй, итгэлцлийн үндсэн дээр оршин тогтнож улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд онцгой үүрэг гүйцэтгэдэг маш чухал салбар билээ. Түүхээс үзвэл манай тооллын өмнөх 3500-аад оны үеэс Месопотамийн хөндийд цэцэглэн хөгжиж байсан эртний хот улсууд болох Шумер, Нинэвэх, Вавилонд өнөөгийн банктай төстэй байгууллагууд үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд тэдгээр нь алт, мөнгөний тогтсон хэмжүүрийг ашиглахын зэрэгцээ арилжаа наймаанд зээл олгодог байв[9] хэмээн тэмдэглэсэн байдаг.

Манай улсын санхүүгийн зах зээлд банкны салбарын эзлэх хувь хэмжээ харьцангуй өндөр буюу 2019 оны эхний хагасын байдлаар 90 гаруй хувьтай байгаа бөгөөд үүнээс шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжүүд санхүүгийн

хэрэгцээгээ үндсэндээ банкны зээлээр бүрдүүлж байна.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2008 онд ДНБ-ийн 56%-тай тэнцэж байсан бол 2019 оны эцэс гэхэд 97% болж нэмэгдсэн байна.

Судалгаанаас үзвэл 2005 - 2019 он хүртэлх сүүлийн 15 жилийн хугацаанд банкны зээлийн эдийн засагт эзлэх хувь хэмжээ харьцангуй нэмэгдсэн байна. Банкны зээл ба ДНБ-ийн харьцаа 2006 онд 30 орчим хувь, 2007-2012 онуудад дунджаар 40 орчим хувь, 2013 онд 60 орчим хувь, 2016-2017 онуудад 70 орчим хувь байгаа нь бага, дунд орлоготой бусад улс орнуудаас (дунджаар 64.0%) харьцангуй өндөр түвшинд байна. Энэхүү зээлийн өсөлтөд хэрэглээний зээлийн өсөлт голчлон нөлөөлсөн байдаг. Тухайлбал, 2019 оны байдлаар нийт зээлийн 58 %-ийг иргэдийн зээл эзэлж байгаа бол 42 % -ийг бизнесийн зээл эзэлж байна.

Манай улсын банкны зээлийн өсөлт нь бусад улс орнуудтай харьцуулахад мөн л өндөрт тооцогдож байна. Тухайлбал, 2009-2018 онуудад банкны зээлийн хэмжээ жилд дунджаар 22%-иар өсөж байсан нь бага, дунд орлоготой бусад улс орнуудаас (дунджаар 12.1%) нилээд өндөр түвшинд байна. Сүүлийн 10 – 15 жилийн эдгээр статистикаас харвал Монгол улсын хувьд төсвийн хөрөнгө оруулалтаас бусад дотоодын хөрөнгө оруулалтын гол эх үүсвэрийг банкны зээл бүрдүүлж байна. Тиймээс бизнесийн орчин нөхцөл харьцангуй сул хөгжсөн, санхүүгийн хөрөнгийн эх үүсвэр дутмаг манай улсын хувьд банкны салбарын эрсдэлгүй, тогтвортой үйл ажиллагаа ихээхэн чухал юм. Дэлхийн банкны Монголын эдийн засгийн тойм: Эдийн засгийн тогтвортой байдал, банкны зээлийн өсөлт хэмээх 2020 оны 1-р сард хэвлэгдсэн судалгааны тайланд “Банкны системийн эмзэг байдал өндөр байгаагийн зэрэгцээ банкуудыг дахин хөрөнгөжүүлэх асуудлыг амжилттай хэрэгжүүлж чадаагүй тохиолдолд олон улсын түншүүдийн туслалцаа, дэмжлэг удаашрах эрсдэлтэйг мөн анхаарах хэрэгтэй” хэмээн тэмдэглэсэн байна.[12]

Манай улс ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагуудаар банкны салбарт Активын чанарын үнэлгээг (AQR) хийлгэж арилжааны банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авсан. Түүнчлэн эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчиддаа хүртээмжтэй, үр ашигтай банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэчлэлийн хөтөлбөрийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлж эхэлсэн. УИХ-ын ажлын хэсэг нь Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиудын

шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Энэ хүрээнд банкны засаглалыг сайжруулах, зээлийн хүүг бууруулах чиглэлээр ихээхэн анхаарч дорвитой өөрчлөлт хийхээр төлөвлөж байна.

Гэхдээ бид банкны зээлийн хүүг бууруулах асуудлыг захиргааны аргаар, хууль тогтоомж батлан гаргах замаар биш улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг бүхэлд нь сайжруулах замаар, зээл болон зээлийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг задлан шинжилж, өөр хооронд нь уялдаа холбоотойгоор авч үзэх замаар, өөрөөр хэлбэл эдийн засгийн арга механизмуудыг ашиглах замаар аажмаар зах зээлийнх нь зарчмаар бууруулах нь зүйд нийцнэ.

## **2. Зээлийн хүүнд нөлөөлж буй гол хүчин зүйлүүд**

Арилжааны банкны зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар онолын болон эмпирик судалгаанууд нилээд хийгдсэн байдаг. Тухайлбал, арилжааны банкны зээлийн хүү болон хадгаламжийн хүүний зөрүүнд гарч буй өөрчлөлт, зээл болон хадгаламжийн хүүг “ex-post” аргаар тооцсон судалгаа [4], Монгол улсын хадгаламжийн хүүнд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээнд Hannan болон Berger (1989, 1991) нарын эмпирик загвар, хүүний зөрүүний шинжилгээнд эрсдэлд дургүй банкны санхүүгийн зуучлалын үйл ажиллагаан дээр суурилсан Maudos болон Guevara (2004) нарын загваруудыг ашигласан тооцоолол [6], [7] Монгол улсын банкны салбарын чанаргүй зээлд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээнд “unit root test”, цувааны өргөтгөсөн тестийг Augmented Dickey Fuller-ADF ашигласан [8] судалгаануудыг дурьдаж болно.

Банкны салбарын нэг чухал бүтээгдэхүүн болох зээл, түүний үнэ болох хүү нь юуны түрүүнд хадгаламжийн хэмжээ, түүний хүү, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, инфляци, валютын ханш, банкны үйл ажиллагааны зардал, зээлийн эрсдэл, бизнесийн орчин нөхцөл, харилцагчдын эрэлт нийлүүлэлт зэрэг макро болон микро олон хүчин зүйлээс шалтгаалдаг.

Монгол банкнаас “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” хэмээх баримт бичгийг боловсруулан энэ хүрээнд 11 зорилтыг дэвшүүлэн ажилласны үр дүнд сүүлийн жилүүдэд зээлийн хүү буурч байна. Үүнийг зээлийн хүүний сүүлийн 5 жилийн дараах статистикаас харж болно. (Хүснэгт 1)

*Хүснэгт 1. Арилжааны банкны зээлийн хүчний динамик*

Он	2016.03	2017.03	2018.03	2019.03	2020.03
Зээлийн хүү, (хувиар)	19.71	20.16	19.1	17.1	16.6

*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

Арилжааны банкны бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хүү нь зээлийн хүүний 65 орчим хувийг бүрдүүлдэг. Үүнд, иргэдийн хадгаламж болон аж ахуйн нэгжийн банкин дахь харилцах дансанд тооцож буй хүү орж байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурлаас баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу харилцах дансны үлдэгдэлд хүү тооцохгүй [1] бөгөөд мөн тус хуулийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон хүү тооцохыг зогсоосон болохыг Монгол банкнаас уламжилсан байна. Тиймээс энэхүү өгүүлэлд арилжааны банкны зээлийн хүү бүрэлдэн тогтоход нөлөөлж буй гол хүчин зүйл болох хадгаламжийн хүү, хадгаламжийн хүүнд нөлөөлдөг гол хүчин зүйлүүд болох инфляцийн түвшин, валютын ханшийн нөлөөллийн талаар авч үзсэн.

**Хадгаламжийн хүү**

Манай улс бол санхүүгийн нөөц, эх үүсвэр багатай улсын тоонд ордог. Тиймээс иргэдэд хуримтлалын сэтгэлгээг төлөвшүүлэх, хуримтлалыг урамшуулан дэмжиж ирсэний үр дүнд сүүлийн жилүүдэд иргэдийн хадгаламжийн хэмжээ тасралтгүй өсөж ирсэн байна. (Хүснэгт № 2) Тухайлбал, хадгаламжийн хүүгийн орлогыг хувь хүний орлогын албан татвараас олон жилийн турш чөлөөлж ирсэн нь үүнийг нэг тод жишээ юм. 2020 оны 4-р сарын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 14.3 их наяд төгрөг байгаагаас 87.3% буюу 12.5 их наяд төгрөг нь иргэдийн хадгаламж, 12.7% буюу 1.8 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. [17]

*Хүснэгт 2. Арилжааны банкин дахь иргэдийн хадгаламжийн динамик*

Он	2016*	2017*	2018*	2019**	2020.04**
Хадгаламжийн хэмжээ (их наяд төгрөгөөр)	7.4	8.9	11.06	12.3	12.5

*Эх сурвалж: \*Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

*\*\* Монгол банк, Мөнгө санхүүгийн статистик. 2019.12 ба 2020.04.*

Арилжааны банкны зээлийн хүүг бууруулах эхний алхам бол харицах дансны үлдэгдэлд хүү тооцох асуудлыг “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” түр хуулийн дагуу зогсоосон явдал бөгөөд цаашдаа үүнийг Банкны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар нэг мөр шийдвэрлэхээр төлөвлөж байна. Ингэснээр зээлийн хүүг 1%-иар бууруулна гэж тооцоолсон байна. [10]

Харин хадгаламжийн хүүг бууруулахын тулд түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг нарийвчлан судалж иж бүрэн арга хэмжээ авах шаардлагатай. Учир нь ямар нэг тооцоо судалгаагүйгээр хадгаламжийн хүүг захиргааны аргаар, арилжааны банкуудад шахалт үзүүлэх замаар бууруулвал банкнаас хадгаламж гадагшлах урсгал нэмэгдэж банкны салбарт санхүүгийн тогтворгүй байдал үүсэх эрсдэлтэй. Ялангуяа санхүүгийн салбарт иргэдийн хувьд сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө байршуулах санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрөл харьцангуй хомс манай улсын хувьд энэхүү гадагшлах урсгал нь олон талын сөрөг үр дүнг дагуулж болзошгүй юм.

Монгол банк, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн судалгаагаар нийт хадгаламж эзэмшигчдийн 99% нь 20 сая хүртэлх төгрөгийн хадгаламжтай иргэд байгаа бөгөөд тэд нийт хадгаламжийн 38%-ийг эзэмшиж байгаа бол 20 саяас дээш төгрөгийн хадгаламжтай иргэд нийт хадгаламж эзэмшигчдийн 1%-ийг эзэлж байгаа бөгөөд тэдний мэдэлд нийт хадгаламжийн 62% нь ноогдож байна.[12] Гэхдээ ийм статистикийг үндэслэн хадгаламжийн хүүг бууруулах асуудлыг шийдвэрлэж болохгүй. Зарим эргэлзээтэй эх үүсвэрээр бүрдүүлсэн их хэмжээний хадгаламжийн хүүний орлогыг бууруулах асуудлыг нийгмийн зүгээс хүчтэй тавьж байгаа тохиолдолд уг асуудлыг хуулийн хүрээнд өөр арга замаар шийдвэрлэх нь илүү оновчтой болно. Сүүлийн жилүүдэд Төв банкны зүгээс авсан арга хэмжээний үр дүнд арилжааны банкны зээлийн хүү аажмаар тасралтгүй буурсаар ирсэн бөгөөд цаашид ч аажим буурах төлөвтэй байгаа юм. (Хүснэгт №3)

*Хүснэгт 3. Арилжааны банкин дахь иргэдийн хадгаламжийн хүүний динамик*

Он	2016.04	2017.04	2018.04	2019.04	2020.04
Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээрх жигнэсэн дундаж хүү (хувиар)	13.4	13.0	12.7	11.8	11.3

*Эх сурвалж: Монгол банк, Мөнгө санхүүгийн статистик. 2016.04-2020.04.*

Дээрх хүснэгтээс үзвэл манай улсын арилжааны банкин дахь иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээрх жигнэсэн дундаж хүү 2016.04-р сарын байдлаар 13.4% байсан бол түүнээс хойш буюу сүүлийн 5 жилийн турш тасралтгүй буурч 2020.04 сард 11.3% болсон байна. Энэ нь арилжааны банкны зээлийн хүү дээрх хугацаанд 19.7% - 16.6% болж буурахад голлох нөлөөг үзүүлсэн. (Хүснэгт 1)

Ийнхүү арилжааны банкин дахь иргэдийн хадгаламжийн хүүг цаашид бууруулах үндсэн нөхцөл нь юуны түрүүнд инфляцийн түвшинг бууруулж, валютын ханшийг тогтворжуулах явдал бөгөөд үүний тулд импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж экспортыг нэмэгдүүлэх, ялангуяа эхлээд экспортын бүтцэд дундаж доод болон дундаж өндөр технологит бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж, улмаар өндөр технологит бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бааз суурийг буй болгох шаардлагатай.

### **Инфляци ба валютын ханш**

Хадгаламжийн хүүний түвшин юуны өмнө инфляцийн түвшинтэй холбоотой. Учир нь мөнгөний цаг хугацааны хүчин зүйлийг тооцох онол арга зүйн үүднээс авч үзвэл хадгаламжийн хүү инфляцийн түвшинтэй ижил юмуу эсвэл доогуур түвшинд очвол иргэд банкинд мөнгөө хадгалуулах нь ашиггүй болно. Тухайлбал, 2019 онд хадгаламжийн хүү дунджаар 11.8%, үүнээс хадгаламжийн хүүний орлогоос 10%-ийн ХХОАТ-ыг хасвал бодит хүү 10.62%, инфляцийн түвшин 5.2% байгаа тохиолдолд иргэдийн олж буй бодит орлогын түвшин 5.42% байна гэсэн үг юм. Инфляци бол бараа бүтээгдэхүүний үнийн ерөнхий түвшингийн өсөлт юм. Манай улсад инфляцийн түвшинг хэрэглээний 12 бүлгийн 373 нэр төрлийн барааны үнийн өсөлтөөр хэмждэг.

Манай улсын инфляцийн түвшин нэг оронтой тоонд байгаа хэдий ч тогтмол буурахгүй, нилээд савалгаатай, жигд бус байна. (Хүснэгт 4)

### *Хүснэгт 4. Инфляцийн түвшин*

Он	2016	2017	2018	2019	2020.04
Инфляци (оны эцэст, хувиар)	1.3	6.4	8.1	5.2	6.2

*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

Дээрх хүснэгтээс үзвэл инфляцийн түвшин 2016 онд 1.3% байсан бол 2018 онд 8.1% болон өссөн бөгөөд 2019 онд 5.2% болж буурсан, 2020 оны эхний 4 сарын байдлаар 4.7%-тай байна. Энэ үзүүлэлт оны эцэс гэхэд дэлхий

дахиньг хамраад байгаа Ковид-19 цар тахлаас шалтгаалан өсөж болзошгүй төлөвтэй байна. Ялангуяа түлш шатахуун, техник хэрэгсэл, өргөн хэрэглээний барааныхаа дийлэнх хэсгийг гаднаас импортолдог манай улсын хувьд валютын ханш тогтмол хурдацтай өсөж байгаа нь инфляцийг нэмэгдүүлэх нэг гол шалтгаан болж байна.

Монгол банкны статистикаас үзвэл 2016 оны 04-р сард 1 ам доллартай тэнцэх төгрөгийн албан ханш 2011.99₮ байсан бол 2020 оны 04-р сарын байдлаар 2783.16₮-т хүрч 2018 онд бага зэрэг буурсныг эс тооцвол сүүлийн 5 жилийн хугацаанд 771.17₮-өөр өссөн байна. (Хүснэгт 5)

#### Хүснэгт 5. Валютын ханш

Он	2016.04	2017.04	2018.04	2019.04	2020.04
Тайлант сарын дундаж ханш (1 ам доллартай тэнцэх төгрөг)	2011.99	2421.85	2394.65	2634.93	2783.16

Эх сурвалж: Монгол банк

Манай улсын хувьд валютын ханшийг тогтвортой барих боломжгүй байгаа өнөөгийн эдийн засгийн бодит нөхцөл байдал нь эргээд иргэдээс төгрөгийн хадгаламжийг долларжуулахад хүргэж, валютын зохиомол эрэлтийг бий болгон ханшийг өсгөж, үүнээс улбаалан инфляцийг хөөрөгдөх нэг шалтгаан болж байна. Иргэдийн хадгаламжийн долларжилтыг хязгаарлах зорилгоор УИХ-аас баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 10.4 дэх хэсэгт “... гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй, иргэн хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ” гэж заасан хэдий ч энэ нь уг асуудлыг шийдвэрлэх төдийлөн үр дүнтэй арга хэрэгсэл биш юм.

Тиймээс юуны түрүүнд эдийн засгийн бүтцийг өөрчилж, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн экспортыг дэмжиж гаднаас орж ирэх валютын урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэж улс орны эдийн засгийн өсөлтийг бүхэлд нь нэмэгдүүлэх замаар валютын ханш болон инфляцийг бууруулах боломжтой бөгөөд энэ тохиолдолд хадгаламжийн хүүг бууруулах бодит нөхцөл аяндаа бүрдэж улмаар арилжааны банкны зээлийн хүү буурах болно.



### Дүгнэлт

1. Манай улсын хувьд арилжааны банкны зээлийн хүүг бууруулж үйлдвэрлэлийг дэмжсэн урт хугацаатай, бага хүүтэй зээлийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг түргэтгэх нэг гол хүчин зүйл болно.
2. Үүний тулд банк, санхүүгийн салбарт шинэчлэл хийх хэрэгтэй бөгөөд үүнийг зөвхөн банкны салбараар үл хязгаарлан банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны зах зээлийн тогтолцоог бүхэлд нь хамруулан хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй болно.
3. Банк, санхүүгийн салбар бол улс орны эдийн засгийн ерөнхий дүр төрхийг илэрхийлж тусгал нь болж байдаг тул энэ салбарт хийж буй өөрчлөлт шинэчлэлтийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгуур асуудлуудтай нягт уялдаа холбоотойгоор авч үзэх шаардлагатай.
4. Арилжааны банкны зээлийн хүүнд хамгийн гол нөлөөлж буй хүчин зүйл бол түүний 65 орчим хувьд шууд нөлөөлж буй хадгаламжийн хүү бөгөөд үүнийг бууруулахын тулд инфляцийн түвшинг бууруулах, экспортыг нэмэгдүүлж валютын ханшийг тогтворжуулах, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих, инновацийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зэргээр улс орны эдийн засгийг бүхэлд нь сайжруулах цогц арга хэмжээг авах шаардлагатай болно.
5. Аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хэрэгцээ нь зөвхөн банкны салбараас хэт хамааралтай байгаа өнөөгийн нөхцөл байдлыг өөрчилж хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, компаниудын IPO-г дэмжих, ингэхдээ компанийн засаглалыг сайжруулж иргэдэд нээлттэй, шударга, ил тод байх зарчмыг тууштай хэрэгжүүлж хариуцлагыг өндөржүүлж, хяналтын арга механизмыг боловсронгуй болгох шаардлагатай. Эдгээр асуудал сул байгаа, түүнчлэн иргэдийн хувьцаанд итгэх итгэл сул, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг мэдээлэл, туршлага хангалтгүй байгаа зэрэг олон шалтгааны улмаас хөрөнгийн зах зээл дорвитой хөгжихгүй байгааг анхаарах ёстой.

### Ашигласан материал

- [1] “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” Монгол улсын хууль. 2020.04.29
- [2] “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Монгол улсын

Засгийн газрын тогтоол. №114. 2020.03.27

- [3] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан [http://www.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_0700\\_018V1](http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0700_018V1)
- [4] Boldbaatar.D (2006), “Measurement and Implication of Commercial Banks` Interest Rate Spread in the Selected SEACEN Countries”, SEACEN Centre.
- [5] Gan-Ochir.D (2006), “Determinants of Bank Interest Rate Spread of Commercial Banks in Mongolia”, working paper #11, The Bank of Mongolia.
- [6] Joaquin Maudos & Juan Fernandez de Guevara (2005) “Factors explaining the interest margin in the banking sectors of the European Union”, In: Journal of Banking and Finance, 28.2259-2281
- [7] Д.Ган-Очир, “Арилжааны банкны зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс” Судалгааны ажил. Товхимол №7, Монгол банк. 2009 он.
- [8] Х.Адъяацогт, Д.Оюу-Эрдэнэ “Монгол улсын банкны салбарын чанаргүй зээлд нөлөөлөх хүчин зүйлс” Бизнес ба Инноваци Улирал тутмын сэтгүүл. 2019.12 (18)
- [9] Дэлхийн түүх. Ерөнхий редактор Адам Харт-Дэвис. Мон судар 2009.
- [10] Б.Батгөмөр: Зээлийн хүү буурах нь банкны салбарын шинэчлэлийг хэрхэн хийхээс шалтгаална. <http://www.npost.mn/a/167228>
- [11] [https://ecrc.mn/media/ecrc/content/Bank%20research/2019/Bank-report-2019Q4\\_mon\\_BkzutEw.pdf](https://ecrc.mn/media/ecrc/content/Bank%20research/2019/Bank-report-2019Q4_mon_BkzutEw.pdf)
- [12] [file:///C:/Users/Class/Documents/Mo%20oguulel%202020.06.08/Mongolia-Economic-Update-Macroeconomic-Stability-and-Credit-Growth%20\(1\).pdf](file:///C:/Users/Class/Documents/Mo%20oguulel%202020.06.08/Mongolia-Economic-Update-Macroeconomic-Stability-and-Credit-Growth%20(1).pdf)
- [13] Монгол банк, Мөнгө санхүүгийн статистик. 2016.04. <https://www.mongolbank.mn/documents/statistic/monetaryreview/2016/04.pdf>
- [14] Монгол банк, Мөнгө санхүүгийн статистик. 2017.04. <https://www.mongolbank.mn/documents/statistic/monetaryreview/2017/04.pdf>
- [15] Монгол банк, Мөнгө санхүүгийн статистик. 2018.04. <https://www.mongolbank.mn/documents/statistic/monetaryreview/2018/04.pdf>
- [16] Монгол банк, Мөнгө санхүүгийн статистик. 2019.04. <https://www.mongolbank.mn/documents/statistic/monetaryreview/2019/04.pdf>
- [17] Монгол банк, Мөнгө санхүүгийн статистик. 2020.04. <https://www.mongolbank.mn/documents/statistic/monetaryreview/2020/04.pdf>